



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	1,700.7	1,700.7
Бараа материал	129,510.4	148,330.5	18,820.1
Үндсэн хөрөнгө	1,216,287.9	1,523,520.0	307,232.1
Нийт хөрөнгө	1,345,798.4	1,673,551.3	327,827.2
Өр төлбөр	74.3	0.0	-74.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,345,724.1	1,672,010.6	327,827.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,345,798.4	1,672,010.6	327,752.9

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 750.0 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, 1 төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Арбулаг сумын ЗДТГ нь 2023 онд бүсийн уулзалтад оролцогчдод бэлэглэх зорилгоор нийт 750.0 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" заалт, 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн зарцуулалт	1	750.0	1	750.0								
Дүн	1	750.0	1	750.0								

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/86
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АРБУЛАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНХУЯГ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 307,232.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Арбулаг сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн хөрөнгөөр 2023 онд бүсийн уулзалтад оролцогчдод бэлэглэх зорилгоор нийт 750.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Арбулаг сумын ЗДТГ-ын дарга нь 3 хөтөлбөр, 7 арга хэмжээний хүрээнд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Арбулаг сумын Засаг даргаар батлуулж, түүнийг 98.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

6724040073

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЗБААТАР

